

ТАНИЛЦУУЛГА

2010 оны 6 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт

1. Цагдаагийн байгууллага 2010 оны эхний 5 сард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 37217 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авсаны 20969 буюу 56.3 хувийг гэмт хэргийн гомдол, эзэлж байна.


Хоёр. Гэмт хэргийн байдал

1. Улсын хэмжээнд энэ оны эхний 5 сард 8326 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 751 хэргээр буюу 8.3 хувиар буурчээ.


Бүртгэгдсэн бүх гэмт хэргийн 55.7 хувь нь нийслэл хотод, 43.3 хувь нь аймгуудад, 0.8 хувь нь Төмөр замын салбарт, 0.2 хувь нь бусад газарт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэргийн гаралт Дорноговь, Увс, Архангай, Говь-Алтай, Баян-Өлгий, Орхон аймагт 2.9-42.9 хувиар, нийслэлийн Баянгол, Налайх дүүрэгт 0.1-24.5 хувь, Төмөр замын салбарт 6.2 хувиар тус тус өсөв.

Гэмт хэргийн гаралт өссөн аймаг /хувиар/




Гэмт хэргийн гаралт өссөн дүүрэг /хувиар/




Харин нийслэлд 8.3, Баянзүрх, Багануур, Хан-Уул, Сүхбаатар, Сонгинохайрхан Чингэлтэй, Багахангай дүүрэгт 1.8-76.9 хувиар, Дархан-Уул, Сэлэнгэ, Баянхонгор, Өмнөговь, Хөвсгөл, Говьсүмбэр, Хэнтий, Өвөрхангай, Ховд, Сүхбаатар, Төв, Дундговь, Дорнод, Булган, Завхан аймагт 4.3-30.6, Иргэний агаарын тээврийн салбарт 80.0 хувиар тус тус буурав.


Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо



Гэмт хэргийн гаралт буурсан аймаг /хувиар/




Гэмт хэргийн гаралт буурсан дүүрэг, салбар /хувиар/



Бүртгэгдсэн бүх гэмт хэргийн 41.3 хувийг хөнгөн, 45.9 хувийг хүндэвтэр, 10.7 хувийг хүнд, 2.1 хувийг онц хүнд ангиллын гэмт хэрэг эзэлж байгаа ба хөнгөн ангиллын гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс 0.2 хувиар өсч, хүндэвтэр ангиллын гэмт хэрэг 14.6, хүнд ангиллын гэмт хэрэг 10.3, онц хүнд ангиллын гэмт хэрэг 1.1 хувиар тус тус буурчээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал




2010 оны эхний 5 сарын байдлаар 18 ба түүнээс дээш насны 10000 хүн тутамд улсын

дунджаар 46 гэмт хэрэг ногдож байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 6 хэрэг буюу 14.3 хувиар буурсан байна.

Дээрх үзүүлэлт Дорноговь аймагт 66, Говьсүмбэр аймагт 61, Хэнтий аймагт 55, Сэлэнгэ аймагт 48, байгаа нь улсын дунджаас 8.9-20.0 хувиар, нийслэлд 61 байгаа нь 15.1 хувиар илүү, Дорнод аймагт 44, Дархан-Уул аймагт 42, Өмнөговь аймагт 42.3, Төв аймагт 41, Орхон аймагт 38.6, Увс аймагт 37, Архангай, Баянхонгор аймагт тус бүр 33, Баян-Өлгий аймагт 31, Ховд аймагт 29, Дундговь аймагт 28, Булган аймагт 25, Хөвсгөл аймагт 23, Говь-Алтай аймагт 22, Сүхбаатар аймагт 20, Өвөрхангай аймагт 21, Завхан аймагт 17 байгаа нь улсын дунджаас 1.8-29.1 хувиар бага байна.

Гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 36.8 хувьтай, өмнөх оны мөн үеийнхээс 1.6 пунктээр, нийслэлийн хэмжээнд 38.9 хувьтай, өмнөх оны мөн үеийнхээс 5.4 пунктээр тус тус өссөн статистик үзүүлэлттэй байна.



Гэмт хэргийн илрүүлэлт Дархан-Уулд 60.5, Увсад 54.0, Дорноговьд 53.3, Ховдод 48.4, Дундговьд 48.1, Архангайд 45.8, Өвөрхангайд 44.4, Говьсүмбэрт 38.1, Баянхонгорт 37.3, Баян-Өлгийд 35.9, Булганд 33.3, Сэлэнгэд 31.3, Төвд 28.0, Говь-Алтайд 26.5, Хэнтийд 26.0, Өмнөговьд 25.0, Сүхбаатарт 24.1, Завханд 22.2, Дорнодод 18.5, Орхонд 18.4, Хөвсгөлд 8.3, нийслэлийн Налайхад 56.3, Баянзүрхэд 49.2, Баянголд 47.7, Хан-Уулд 41.6, Багануурт 40.0, Чингэлтэйд 32.0, Сүхбаатарт 28.7, Сонгинохайрханд 27.2, Төмөр замын салбарт 31.6 хувьтай байна.

Гэмт хэргийн илрүүлэлтийг ангиллаар нь тооцож үзвэл: Хөнгөн гэмт хэргийн илрүүлэлт 35.7, хүндэвтэр гэмт хэргийн илрүүлэлт 34.4, хүнд гэмт хэргийн илрүүлэлт 54.3, онц хүнд гэмт хэргийн илрүүлэлт 46.2 хувьтай байгаа нь хөнгөн хэргийн илрүүлэлт өмнөх оны мөн үеийнхээс 6,9, хүндэвтэр хэргийн илрүүлэлт 0.4, хүнд хэргийн илрүүлэлт 6.7 пунктээр өсч, онц хүнд хэргийн илрүүлэлт 26.8 пунктээр буурчээ.



Мал хулгайлах гэмт хэрэг 386 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 34.2 хувиар буурч, нийт хэргийн 4.6 хувийг, бусдын эд хөрөнгийг хулгайлах хэргийн 16.3 хувийг, тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг 36 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 10 хувиар буурч, хулгайлах хэргийн 1.5 хувийг, халаасны хулгайн хэрэг 73 бүртгэгдэж, хулгайлах хэргийн 3.0 хувийг тус тус эзэлж байна.

2010 оны эхний 5 сард улсын хэмжээнд 243174 захиргааны эрх зүйн зөрчил бүртгэгдэж, 48330 хүн эрүүлжүүлэгдэж, өмнөх оны мөн үеийнхээс захиргааны эрх зүйн зөрчил 33.0, эрүүлжүүлэгдсэн хүн 18.7 хувиар тус тус буурсан болно.